

ᠠᠭᠠᠠᠷᠢᠨ ᠪᠣᠬᠢᠷᠳᠤᠯᠢᠭ ᠪᠤᠭᠤᠷᠤᠭᠤᠯᠠᠬᠤ ᠤᠨᠳᠡᠰᠨᠢᠶ
ᠬᠣᠷᠤᠨ ᠭᠢᠰᠢᠭᠦᠳᠢᠶᠢᠨ ᠤᠦᠷᠭᠡᠭ, ᠬᠠᠮᠲᠤᠨ ᠠᠵᠢᠯᠢᠯᠠᠭᠠᠭᠠ



АГААРЫН БОХИРДЛЫГ
БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ
ХОРОО

АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ГИШҮҮДИЙН ҮҮРЭГ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА
С.ДАВААСҮРЭН

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ



Агаарын тухай хуулийн Засгийн газрын бүрэн эрх: 6.1.1¹. Агаарын бохирдлыг бууруулах бодлогын хэрэгжилтийг зохицуулах, үйл ажиллагааны харилцан уялдааг хангахад хяналт тавих чиг үүрэг бүхий Үндэсний хороо байгуулж ажиллуулах;



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 211

Улаанбаатар хот

ТОГТООЛ, ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Агаарын тухай хуулийн 6.1.1¹-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

- 1."Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 21 дүгээр тогтоолд агаарын бохирдлыг бууруулах бодлогын хэрэгжилтийг зохицуулах, үйл ажиллагааны харилцан уялдааг хангахад хяналт тавих чиг үүрэг бүхий "Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны бүрэлдэхүүн" гэсэн 46 дугаар хавсралт нэмсүгэй.
- 2.Мөн тогтоолын 1 дэх заалтын "45 дугаар хавсралт" гэсний дараа ", Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 46 дугаар хавсралт" гэж нэмсүгэй.
- 3.Энэ тогтоолын хавсралтаар баталсан Үндэсний хорооны ажиллах журмыг баталж, хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Үндэсний хорооны дарга С.Одонтуяад даалгасугай.
- 4.Энэ тогтоолын 1-д заасан Үндэсний хорооны үйл ажиллагаанд шаардагдах зардлыг батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлэхийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Үндэсний хорооны дарга С.Одонтуяад үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 08 сарын 20 өдөр

Дугаар 57

Улаанбаатар хот

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, "Засгийн газарт чиглэл өгөх тухай" Улсын Их Хурлын 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 53 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

- 1."Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 46 дугаар хавсралтаар баталсан "Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны бүрэлдэхүүн"-ий "Дэд дарга: -Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч" гэсний дараа "-Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд" гэж нэмсүгэй.
- 2.Мөн тогтоолын хавсралтын "Дарга: -Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд" гэснийг "Дарга: -Монгол Улсын Ерөнхий сайд" гэж өөрчилсүгэй.
- 3.Мөн тогтоолын хавсралтын "Гишүүд:" хэсгийн "-Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга, -Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны дарга," гэснийг тус тус хассугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА С.БЯМБАЦОГТ



АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Дэд дарга: -Байгаль
орчин уур амьсгалын
өөрчлөлтийн сайд

Дэд дарга: - Нийслэлийн Засаг
дарга бөгөөд Улаанбаатар хотын
Захирагч

Монгол Улсын Засгийн
газрын гишүүд

Агентлаг, ААН

Нарийн бичгийн
дарга

- ❖ Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд
- ❖ Сангийн сайд
- ❖ Хууль зүй, дотоод хэргийн сайд
- ❖ Боловсролын сайд
- ❖ Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
- ❖ Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд
- ❖ Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд
- ❖ Эрчим хүчний сайд
- ❖ Эрүүл мэндийн сайд

➤ Агентлаг

- ❖ Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх (зөвшилцсөнөөр)
- ❖ Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга
- ❖ Онцгой байдлын ерөнхий газрын дарга
- ❖ Цагдаагийн ерөнхий газрын дарга
- ❖ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны Стратегийн бодлого, дүн шинжилгээний газрын дарга
- ❖ Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэнгийн захирал
- ❖ Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч

➤ Аж ахуй нэгж

- ❖ "Таван толгой түлш" ХХК-ийн гүйцэтгэх захирал

- ❖ Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга

- ❖ Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газрын дарга

АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ГИШҮҮДИЙН ҮҮРЭГ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

АББҮХ-НЫ ГИШҮҮД		ЧИГ ҮҮРЭГ
Монгол Улсын Ерөнхий сайд	Дарга	Үндэсний хорооны хурлыг товлон зарлаж, хэлэлцэх асуудлыг батална. Хурлыг даргална.
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	Дэд дарга	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, ногоон хөгжлийн талаарх хууль тогтоомжийн хүрээнд хүлэмжийн хийн ялгарал, бохирдлыг бууруулах инновацыг хөгжүүлж, цэвэр технологи, ногоон хөгжлийг дэмжих, байгаль орчны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн шинжлэх ухаан технологийн судалгааг өргөжүүлж, судалгаа, үр дүнд суурилсан бодлогыг төлөвлөн хэрэгжүүлэхэд чиглүүлэх. Үндэсний хорооны даргын эзгүйд хурлыг даргална.
Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч	Дэд дарга	Нийслэл Улаанбаатар хотын эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх, Үндэсний хорооны даргын эзгүйд хурлыг даргална.
Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	Гишүүн	Эдийн засаг нийгмийн хөгжлийн бодлогыг тодорхойлон, эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх замаар, төр хувийн хэвшлийн түншлэлийг хариуцна.
Сангийн сайд	Гишүүн	Тусгагдсан санхүүгийн салбарын бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд бусад яам, газруудын үйл ажиллагааны уялдааг хангах, санхүүгийн төлөвлөлт, зохицуулалтад шаардлагатай зөвлөгөө, үйлчилгээг мэргэшлийн өндөр түвшинд үзүүлнэ.
Хууль зүй, дотоод хэргийн сайд	Гишүүн	Хууль зүйн нэгдсэн бодлогоор хангах ажлыг зохион байгуулна.
Боловсролын сайд	Гишүүн	Боловсролын байгууллагуудын зөв оновчтой бодлогыг тодорхойлох, мэдээллээр ханган чиглүүлнэ.
Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	Гишүүн	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар хоорондын бодлогын уялдааг хангаж, нэгдсэн төлөвлөлт хийх, удирдамжаар хангах, Зорилтот бүлгийн айл өрхийг сайжруулсан зуух, түлш болон цахилгаан халаагуураар хангахад дэмжлэг үзүүлнэ.
Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд	Гишүүн	Харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэхэд салбар хоорондын уялдааг хангана.
Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	Гишүүн	Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтыг боловсруулах, хот дахин төлөвлөлтийг хөгжүүлэх, хүнд ээлтэй шинэ орчин, нөхцөлийг бүрдүүлэх, авто замын түгжрэлийг бууруулах талаар бодлого боловсруулана.
Эрчим хүчний сайд	Гишүүн	эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болгох, бүс нутгийн шугам сүлжээ байгуулах, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх, эрчим хүчний нүүрсний болон шинэ, хийн түлшний технологийг хөгжүүлэх. эрчим хүч, түлш (эрчим хүчний нүүрс)-ни салбарт шинжлэх ухаан, технологи, эрчим хүчний балансын судалгаа, стандарт, норм, нормативын баримт бичиг, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийж, эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.
Эрүүл мэндийн сайд	Гишүүн	Агаарын бохирдлоос хүн амын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл болон эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга барилыг төлөвшүүлэх сургалт, сурталчилгаа, хамгааллын арга хэмжээг зохион байгуулна. ,

АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ГИШҮҮДИЙН ҮҮРЭГ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

АББУХ-НЫ ГИШҮҮД	ҮҮРЭГ	ЧИГ ҮҮРЭГ
Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх (зөвшилцсөнөөр)	Гишүүн	Монгол Улсын Ерөнхийлөгчийг мэдээллээр хангаж, Ерөнхийлөгчөөс өгсөн үүрэг чиглэлийг Үндэсний хороонд танилцуулах.
Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга	Гишүүн	Монгол Улсын Ерөнхий сайдыг мэдээллээр хангаж, Ерөнхий сайдаас өгсөн үүрэг чиглэлийг Үндэсний хороонд танилцуулах.
Онцгой байдлын ерөнхий газрын дарга	Гишүүн	Гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлж бэхжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шинжлэх ухаан, инновацыг нэвтрүүлэх, Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүх нийтийн үйл хэрэг болгон, иргэд, олон нийтийн гамшгаас хамгаалах мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, гамшгийн эрсдэлийг бууруулахад олон нийтийн оролцоог хангах
Цагдаагийн ерөнхий газрын дарга	Гишүүн	Хүн амыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх, хяналт шалгалтыг зохион байгуулах.
Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны Стратегийн бодлого, дүн шинжилгээний газрын дарга	Гишүүн	Үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн нэгдмэл бодлого боловсруулах үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэх явдлыг уялдуулан зохицуулах, энэхүү зохицуулалт нь хэрхэн хангагдаж байгаад хяналт тавих
Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэнгийн захирал	Гишүүн	Гамшгийн эрсдэлийг бууруулах, судалгаа шинжилгээ хийх
Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч	Гишүүн	Нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах бодлогыг хэрэгжүүлэх, иргэдийн дунд мэдээлэл, үйлчилгээ үзүүлэх
"Таван толгой түлш" ХХК-ийн гүйцэтгэх захирал	Гишүүн	Чанарыг эрхэмлэн хямд үнэ өртөг бүхий бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн зах зээлд нийлүүлэхийн зэрэгцээ агаарын бохирдлыг бууруулахад бодитой хувь нэмрээ оруулах
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга	Нарийн бичгийн дарга	Хурлын зохион байгуулалтыг хариуцаж, холбогдох шийдвэрийн төслийг боловсруулж санал авах.
Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газрын дарга.	Нарийн бичгийн дарга	Хурлын зохион байгуулалтыг хариуцаж, холбогдох шийдвэрийн төслийг боловсруулж санал авах.

АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ГИШҮҮДИЙН ҮҮРЭГ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2025-2026 оны Нэгдсэн төлөвлөгөөнд нийт 38 арга хэмжээнд тус тусын чиг үүргээр хамтран оролцож байна.





АНХААРАЛ
ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА

QR КОДЫГ УНШУУЛАН, АГААРЫН
БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ФЭЙСБҮҮК
ХУУДАСНААС МЭДЭЭЛЭЛ АВАХ

